# ХДХВ/БЗДХ-ын талаарх оюутан залуучуудын мэдлэг, дадал, хандлагыг судалсан нь

*Т.Дөлгөөн[1], Д.Гантуяа[2], С.Мягмарчулуун[2]*

*[1,2]АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль*
*Цахим шуудан: eph22e001@gt.mnums.edu.mn, Утас: 88088169*

**Түлхүүр үг:**

Мэдээллийн хүртээмж
Бэлгэвчний хэрэглээ
Сайн дурын үзлэг, шинжилгээ
ХДХВ
БЗДХ

**Үндэслэл:** Дэлхий даяар өдөр бүр 1 сая гаруй бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) авдаг ба 15-49 насны 500 сая гаруй хүн энгийн герпес вирусын (HSV) бэлэг эрхтний халдвартай гэсэн тооцоо бий. Монгол улсад Глобал сангийн дэмжлэгтэйгээр ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгааг 2002 оноос эхлэн хийсэн ба судалгааны үр дүнг үндэсний хэмжээнд ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг төлөвлөх, эмчилгээ, тусламж үйлчилгээний хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, “Дэлхийн ДОХ-ын асуудлаарх хяналт үнэлгээний тайлан”-гийн шалгуур үзүүлэлтүүдийг тайлагнахад мэдээллийн үндсэн эх сурвалж болдог. **Зорилго:** Улаанбаатар хотын зарим их сургуулийн оюутан, залуучуудын дундах ХДХВ/БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэхэд оршино. **Арга, аргачлал:** Судалгаанд АШУҮИС, ШУТИС-ийн 1-5-р дамжааны 410 оюутан залуучуудыг хамруулсан ба судалгааг нэг агшингийн загвараар гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулах асуумжийн хуудсыг google form аппликайшн ашиглан цуглуулж, статистик боловсруулалтыг STATA 23 программ ашиглан хийсэн. **Үр дүн:** Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын ХДХВ,БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшин 80.6%, эмэгтэй оюутнуудын хувьд 84.1% нь, эрэгтэй оюутнууд хувьд 77.2% нь хангалттай мэдлэгтэй байна. Оюутнуудын бэлгэвчийн хэрэглээг зөвхөн бэлгийн хавьталд орсон оюутнуудын авч үзэхэд нийт оюутнуудын 50% нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн бол 49.7% нь сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаануудыг тодруулахад бэлгийн хавьтагчдаа итгэдэг, бэлгэвч хэрэглэх дургүй, тухайн үед олдоогүй, жирэмслэлтээс хамгаалах өөр арга хэрэглэдэг зэрэг шалтгаанууд хамгийн өндөр хувьтай байсан. Оюутан залуусын дунд БЗДХ-аас сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар судлаха 84% нь хангалтгүй гэж хариулсан байна. **Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан оюутнуудын ХДХВ,БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшин хангалттай боловч дадал ханаглтгүй байна. Оюутан залуусын дунд БЗДХ-аас сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй гэж үзсэн нь цаашид энэ үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Үндэслэл:** Монгол Улсын Засгийн газраас ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөөг 2003 онд анх удаа хэрэгжүүлсэн ба 2006-2010 оны үндэсний стратеги төлөвлөгөө нь ХДХВ-ийн халдварын тархалтаас сэргийлэхэд өсвөр үе, залуучуудын мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдгээрийн эрсдэлт ба өртөмтгий байдлыг бууруулахад чухал онцгой анхаарсан[1]. Монгол улсад 2021 оны байдлаар 456347 өсвөр насныхан, залуучууд (15-24 нас) эзэлж байгаа ба ДЭМБ-ын тайлан мэдээнд өсвөр үеийнхний эрүүл мэндийн гол тулгамдаж буй асуудалд шээс бэлгийн замын өвчин, хоол боловсруулах эрхтний эмгэг, осол гэмтэл, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт болон амьдралын буруу хэв маяг, зан үйл, түүнээс 18% нь дээрх шалтгаанаас үүдэлтэй байна[2].

**Зорилго:** Улаанбаатар хотын зарим их сургуулийн оюутан, залуучуудын дундах ХДХВ/БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэхэд оршино.

**Арга, аргачлал:** Судалгааг АШУҮИС, ШУТИС-ийн 1-5-дугаар дамжааны 410 оюутан залуучуудыг хамруулан АШУҮИС-ийн Био-Анагахааын ёс зүйн хорооны 2022 оны 05 сарын 13 өдрийн 1/102 тоот хурлаар судалгааны аргачлалыг хэлэлцүүлж, судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл авч, аналитик судалгааны нэг агшингийн загвараар гүйцэтгэж, мэдээлэл цуглуулах асуумжийн хуудсыг google form холбоосыг ашиглан цуглуулсан. Статистик боловсруулалтыг STATA-23 программыг ашиглан хийсэн.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан эмэгтэй оюутнуудын ХДХВ,БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшин 84.1%, эрэгтэй оюутнууд 77.2% байна. Суралцаж буй сургуулийн хувьд АШУҮИС-ийн оюутнуудын мэдлэгийн түвшин 88.8% бол ШУТИС-ийн оюутнуудын мэдлэгийн түвшин 72.7% байсан. (Хүснэгт 1)

**Хүснэгт 1. ХДХВ, ДОХ/БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшин**

| ХДХВ, ДОХ/БЗДХ-ын талаарх мэдлэг (%) | Эрэгтэй | Эмэгтэй | АШУҮИС | ШУТИС |
|---|---|---|---|---|
| Хангалттай | 77.2 | 84.1 | 88.8 | 72.7 |
| Хангалтгүй | 22.8 | 15.9 | 11.2 | 27.3 |
| Нийт | | | | 100 |
| P утга (Pr) | | | | 0.076 |

ХДХВ,БЗДХ дамжихаас сэргийлэх талаар болон халдвар дамжих замын талаар зөв ойлголттой мэдлэгийн түвшинг судалгаанд оролцсон оюутнуудыг суралцаж буй дамжаагаар үзэхэд дамжаа ахих бүрт мэдлэгийн түвшин ахисан үзүүлэлт гарсан. Судалгаанд оролцогчдын амьдарч буй хэв шинжээр нь мэдлэгийн түвшинг үнэлж үзэхэд гэртээ найз залуу/охинтойгоо хамт амьдардаг оролцогчдын мэдлэгийн түвшин илүү сайн байсан. Оюутнуудын бэлгэвчний хэрэглээг зөвхөн бэлгийн хавьталд орсон оюутнуудын хувьд судлахад 50% нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн бол 49.7% нь сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Бэлгийн хавьталд орсон оюутнуудаас бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орсон шалтгаануудыг тодруулахад бэлгийн хавьтагчдаа итгэдэг, бэлгэвч хэрэглэх дургүй, тухайн үед олдоогүй, жирэмслэлтээс хамгаалах өөр арга хэрэглэдэг зэрэг шалтгаанууд хамгийн өндөр хувьтай байна. (Хүснэгт 2)

**Хүснэгт 2. Бэлгэвч хэрэглэхээс татгалзсан шалтгаан**

| Бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан | Нийт | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|
| Бэлгэвч хэрэглэх дургүй | 19.5 | 18.2 | 20.6 |
| Тухайн үед бэлгэвч олдоогүй | 13.2 | 14.4 | 11.3 |
| Бэлгэвч авах цаг, зав гараагүй | 5 | 5 | 5.1 |
| Бэлгэвч үнэтэй | 0.7 | 1.2 | 0 |
| Бэлгэвч худалдаж авахад эвгүй, ичдэг | 1.1 | 1.2 | 1 |
| Би бэлгэвчинд итгэдэггүй | 0.7 | 0.5 | 1 |
| ХДХВ, БЗДХ-аас хамгаалах өөр арга хэрэглэдэг | 8.2 | 8.1 | 8.2 |
| Бэлгийн хавьтагч дургүйцдэг | 3.1 | 3.1 | 3 |
| Бэлгийн хавьтагчдаа би итгэдэг | 12.8 | 13.2 | 12.3 |
| Би согтуу байсан | 0.7 | 1.2 | 0 |
| Жирэмслэлтээс сэргийлэх өөр арга хэрэглэдэг | 13.6 | 10 | 19.5 |
| Намайг өвчтэй гэж бодно | 0.7 | 0.6 | 1 |
| Бэлгэвч хэрэглэхээ мартсан | 8.9 | 9.4 | 8.2 |
| Бэлгэвчийг өөртөө хангалттай хэмжээгээр авч явдаггүй | 6.2 | 8.2 | 4.1 |
| Бусад | 4.6 | 5 | 4 |
| **Нийт хариулагчдын тоо** | **256** | **159** | **97** |

Санхүүгийн болон эд материалын тусламж үзүүлээд бэлгийн хамтрагч болох санал авч байсан эсэхийг нь судлахад оюутнуудын 85.3% нь огт үгүй гэж хариулсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд хамрагдсан оюутнуудын 3%-д БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн ба үүнээс 11.2% нь эмчлүүлсэн байна.

Сайн дурын үзлэг шинжилгээнд оюутнуудын 28.4% нь хамрагдаж байсан ба уг үзүүлэлт хүйсийн хувьд статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна. Харин шинжилгээ хийлгэх шийдвэр гаргалтын хувьд эрэгтэй оюутнуудын 50% нь эмэгтэй оюутнуудын 24.8% нь шаардлага гарсны улмаас шинжилгээ хийлгэсэн байна. Шинжилгээ хийлгэсэн эрэгтэй оюутнуудын 1.5%, эмэгтэй оюутнуудын 0.4% нь эерэг гэсэн хариу авч байжээ. (Хүснэгт 3)

**Хүснэгт 3. Сайн дурын үзлэг шинжилгээний талаар**

| Үзүүлэлтүүд | Хариулт | Эрэгтэй % | Эмэгтэй % |
|---|---|---|---|
| Сайн дурын үзлэг шинжилгээнд хамрагдаж байсан эсэх | Хийлгэж байсан | 26.2 | 30.7 |
| | Хийлгэж байгаагүй | 73.7 | 69.2 |
| Шинжилгээ хийлгэж байсан шийдвэр гаргалт | Сайн дураараа | 20.4 | 19.3 |
| | Шинж тэмдэг илэрсний улмаас | 1.5 | 1.5 |
| | Шаардлага гарсны улмаас | 19.6 | 24.8 |
| | Бэлгийн хавьталд ороогүй | 12.2 | 24.8 |
| | Бусад | 46.2 | 29.4 |
| Шинжилгээний хариу эерэг байна гэж гарсан эсэх | Тийм | 1.5 | 0.4 |
| | Үгүй | 81.6 | 79.3 |
| | Хариугаа аваагүй | 6.4 | 1.9 |
| | Бэлгийн хавьталд ороогүй | 10.4 | 18.3 |
| Сүүлийн 12 сард ХДХВ,БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамрагдсан эсэх | Тийм | 21.7 | 18.7 |
| | Үгүй | 78.2 | 81.2 |
| Хамрагдсан үйл ажиллагааны төрөл | Сургалт | 50 | 44.7 |
| | Бүлгийн ярилцлага | 0 | 10.5 |
| | Сайн дурын зөвлөгөө, шинжилгээ | 21.4 | 18.4 |
| | Бэлгэвч хүлээн авсан | 19 | 18.4 |
| | БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ | 0 | 2.6 |
| | Бусад | 9.5 | 5.3 |
| ХДХВ,БЗДХ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх бол очих газраа мэдэх эсэх | Тийм | 57.4 | 64.4 |
| | Үгүй | 42.5 | 35.5 |
| **Нийт хариулагчдын хувь** | | **100** | **100** |

Нийт судалгаанд оролцсон оюутнуудын дунд оюутан залуусын дунд БЗДХ-аас сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалттай эсэх талаар асуумж авахад 84% нь хангалтгүй, 16% хангалттай гэж хариулсан байна.

БЗДХ-аас сэргийлэх урьдчилсан сэргийлэх, бууруулах чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны хувьд нийт оюутнууд сургалт явуулах 37%, хөтөлбөр хэрэгжүүлэх 18.7%, урьдчилсан сэргийлэх үзлэх хийх үйл ажиллагаа явуулах 19% нь үр дүнтэй байна.

**Хэлцэмж:** Төрийн өмчит их сургуулийн оюутнуудын дунд БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын онлайн судалгаагаар (2017 он) оюутнуудын дунд БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшинг судлаж үзэхэдсудалгаанд хамрагдсан оюутнуудын 30.3% нь сайн, 69.6% ньхангалтгүй түвшинд байсан бол бидний судалгаагаар АШУҮИС-ийн оюутнуудын мэдлэгийн түвшин 88.8% бол ШУТИС-ийн оюутнуудын мэдлэгийн түвшин 72.7%-ийг эзэлж байгаа нь мэдлэгийн түвшин нэмэгдсэн байлаа[3].

Африкийн өмнөд хэсэгт ХДХВ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх мөн мэдлэг, хандлага, дадлыг тогтмол үнэлэх зорилгоор их сургуулийн оюутнуудын дунд хийгдсэн (2017 он) судалгааны дүнд бэлгэвчний хэрэглээ эмэгтэй оюутнуудын 4%, эрэгтэй оюутнуудын 15% байгаа нь оюутан залуусыг өндөр эрсдэлтэй бүлэгт тооцох шалтгаан болсонгэж үзсэн бол бидний судалгаагаар оюутнуудын бэлгэвчний хэрэглээг зөвхөн бэлгийн хавьталд орсон оюутнуудын хувьд суралцдаг сургуулийг хүйсээр нь ангилан үзэхэд нийт оюутнуудын 50% нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн, 49.7% нь сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байгаа нь бэлгэвчний хэрэглээ өндөр хувьтай байгааг харуулж байна[4].

Судлаач Н.Оюунболор нарын (2008 он) Улаанбаатар хотын дотуур байрны оюутнуудын дунд хийсэн чанарын судалгаагаарбэлгэвч хэрэглэх нь БЗДХ болон хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх үр дүнтэй арга гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч ХДХВ/ДОХ өвчлөлийн талаар буруу ташаал ойлголтой оюутнуудын тоо харьцангуй өндөр байсан бол бидний судалгаагаар ХДХВ/БЗДХ-ын талаарх мэдлэгийг зөв тодорхойлж, буруу ойлголтыг үгүйсгэсэн оюутнуудын эзлэх хувь өндөр байсан[5].

Судлаач Л.Шинэцэцэг нарын (2017 он) их дээд сургуулийн оюутнуудын БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж, түүнд гарч буй өөрчлөлтийг үнэлсэн судалгаагаар оюутнуудын БЗДХ-ын талаарх мэдлэг, өвчний шинж тэмдэг, үр дагаврын талаарх мэдээлэл хангалтгүй байна[6]. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 67.4% нь БЗДХ-ын талаарх мэдээллийг цахим байдлаар авах хэрэгцээтэй байсан бол бидний судалгаагаар БЗДХ-аас сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нийт оюутнуудын хувьд хангалтгүй байгаа ба мэдээлэл авах хэрэгцээтэй эх үүсвэр нь сошиал сувгуудаар гэж 50% нь хариулсан байсан.

**Дүгнэлт:** Судалгаанд хамрагдсан оюутнуудын ХДХВ,БЗДХ-ын талаарх мэдлэгийн түвшин 80.6% байна. Бэлгэвчний хэрэглээний хувьд оюутнуудын 50% нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн, 49.7% нь сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна. Оюутан залуусын дунд БЗДХ-аас сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 84% нь хангалтгүй гэж үзсэн нь цаашид энэ үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Ном зүй:**

1. *ЭМЯ. БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө (2012-2015). Улаанбаатар: 2012*
2. *А.Болормаа. Завхан аймгийн өсвөр үеийнхний дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох нь 2017 он*
3. *Ч.Өнөрцэцэг. Төрийн өмчит их сургуулийн оюутнуудын дунд БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын онлайн судалгааны тайлан, Улаанбаатар 2017 он*
4. *Dr. Zübeyde EKŞİ**, Prof. Dr. Nuran KÖMÜRCÜ, et al. Knowledge level of university students about sexually transmitted diseases, Zü beyde Ekşi and Nuran Kömürcü / Procedia - Social and Behavioral Sciences 122 ( 2014 ) 465 – 472*
5. *Оюунболор Н, Мөнхтүвшин Н, Лхагвасүрэн Б, Улаанбаатар хотын дотуур байранд амьдардаг оюутны нийгэм сэтгэл зүйн чанарын судалгаа, Улаанбаатар: 2008 он*
6. *Л.Шинэцэцэг. БЗДХ-ын талаарх оюутнуудын мэдлэг, хандлага, дадлын судалгаа, Улаанбаатар: 2017 он*

# The study to evaluate the knowledge, practices and attitudes of students and youths about HIV/STDS

*Dulguun T[1], Gantuya D[2], Myagmarchuluun S[2]*

*[1,2]School of Public Health, MNUMS*
*E-mail: eph22e001@gt.mnums.edu.mn, Tel: +976-88088169*

**Background:** It is estimated that more than 1 million people are being getting with sexually transmitted diseases (STDs) daily in a wordlwide, and more than 500 million people between the ages of 15 and 49 are infected with genital herpes simplex virus (HSV). In Mongolia, with the support of the Global Foundation, HIV and STD surveillance research was conducted starting in 2002, and the results of the study are the main information source to plan measures to prevent and reduce the spread of HIV, AIDS, and STDs at the national level, to evaluate the results of treatment and care programs, and for reporting criterias; Global AIDS Monitoring and Evaluation Repor;.

**Aim:** We aimed to evaluate the knowledge, practice and attitude regarding HIV/STDs among students and youths of some universities in Ulaanbaatar**.**

**Materials and Methods:** In the study, 410 students of the 1st-5th year of MNUMS and MUST were included and the study was conducted by using cross sectional design. Questionnaires were used to collect data by google form application and statistical analysis was made by using STATA software.

**Results:** The level of knowledge about HIV and STDs among female students who participated in the study was 84.1%, and it was 77.2% among male students. As for the studied universities, the level of knowledge of the students of MNUMS was 88.8%, while the level of knowledge of the students of MUST was 72.7%. When students; condom use was classified by gender and type of university they attended among only students who had intercourse, 50% of all students used condoms for the first time they had intercourse, and 49.7% used condoms for the last time they had intercourse.

Among the students who had intercourse, the reasons for having intercourse without a condom were found to be the reasons such as trusting their sexual partners, not liking to use condoms, not finding them at the time, and using other methods of contraception. Moreover, 28.4 percent of students were tested for HIV infection, and this parameter did not differ by gender. Among the students who participated in the survey, 84% answered that the measure taken to prevent STDs among young students were insufficient, and 16% of them answered that it is sufficient. Furthermore, in terms of action to prevent from STDs and reducing its incidences, 37 percent of all students voted for the effectiveness of conducting training, 18.7 percent of program implementation, and 19 percent of preventive screening activities are effective.

**Conclusion:** The level of knowledge regarding HIV and STDs among the surveyed students is good and practice is not enough. The fact of the measures taken to prevent STDs among young students are insufficient indicates the need to intensify this measures in the future.

**Keywords:** Access information, Condom use, Voluntary screening, Human immunodeficiency virus, Knowledge of sexually transmitted disease